

3

**МОНГОЛ УЛС ДАХЬ ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
БА ДНБ-ИЙ ӨСӨЛТИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ**

Н.Батнасан

1990-2003 онуудад нэг хүнд ногдох шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 386.8 дахин өссөн¹ бол ДНБ-ий ердөө л 10.5%-иар өссөн нь дэлхийн дунджаас 3.7 дахин доогуур² байна.

Иймээс Монгол улсад хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалтын болон эдийн засгийн өсөлтийн харилцан хамаарлыг судалж, түүнд шинжилгээ хийх шаардлагатай байгаа юм. Энэ нь гадаадын хөрөнгө оруулалтын талаархи бодлогын шийдвэрүүдийг боловсруулж, тодорхойлоход нэн чухал ач холбогдолтой зүйл билээ.

Олонхи судалгааны ажлууд ГШХО-ыг хийж буй хөрөнгө оруулагч орны зүгээс хөдөлмөр, үйлдвэрлэлийн бүтээмжид ямар нөлөөлөл үзүүлснийг төвлөрч судалсан байдаг. Харин энд арай өөр байдлаар, тодруулбал Balasubramanyam болон бусад эрдэмтэд (1996), түүнчлэн Sarkovic & Levine (2002) нарын ДНБ-ий өсөлтийг ГШХО-тай холбож, түүнийг хөдөлмөр ба капиталын өсөлттэй зүйрлэн, ердийн үйлдвэрлэлийн функц дээр тусгаж судалсан загварыг авч ашиглав.

Монгол шиг бага буурай оронд гадаадын хөрөнгө оруулалт дотоодын хөрөнгө оруулалттай харьцуулахад илүү сайн технологи, илүү өндөр мэргэжилтэй ажиллах хүчнийг дагуулан авч ирдэг гэдэгтэй маргахгүй болов уу. Үүнээс үндэслэн дээрх загварт үйлдвэрлэлийн функцэд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг тус тусад нь үл хамаарах хувьсагч болгон авч үзсэн байдаг. Тиймээс бид үйлдвэрлэлийн функцыг ердийн хэлбэрээр дараахь байдлаар томъёолж болох юм:

¹ГХГХОА-ийн мэдээ. "World Investment Report 2004"-т тулгуурлан хийсэн зохиогчийн тооцоолол
²World Bank "World Development Indicators". "Монгол улс зах зээлд" статистикийн эмхтгэл. "Монгол улсын статистикийн эмхтгэл-2003"-т тулгуурлан хийсэн зохиогчийн тооцоо

$$Y=g(L, K, F, t) [1]$$

Энд Y-ээр бодит ДНБ-ий хэмжээг, L-ээр хөдөлмөрийг, K-аар дотоодын капиталын өртгийг, F-ээр гадаадын капиталын өртгийг, t-ээр техникийн дэвшлийг харуулах цаг хугацааны хандлагыг төлөөлүүлэв. Дээрх функцыг шугаман хэлбэрт оруулахын тулд 2 талаас нь Log авахад ДНБ-ий өсөлт нь дараахь хэлбэрээр илэрхийлэгдэж байна.

$$y = \alpha + \beta_1 l + \beta_2 k + \beta_3 f [2]$$

Томьеонд байгаа жижиг үсгүүд нь өсөлтийн хувийг, бета коэффициент нь ДНБ-ий өсөлтийн мэдрэмжийг илэрхийлдэг. Гадаадын болон дотоодын капиталын өртгийг Balasubramanyam нар (1996) ДНБ-д гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтын эзлэх хувийн жинг оруулан ашигласан бөгөөд бид энэхүү тооцоондоо энэхүү аргыг ашиглав. Учир нь гадаадын болон дотоодын капиталын өртгийн хэмжээг цаг хугацааны үргэлжлэлд тооцож гаргасан статистик мэдээлэл байхгүй юм..

$$GDP = 6.67l^{0.85} k^{0.18} f^{0.8}$$

Тооцооноос үзэхэд ДНБ-ий өсөлт гадаад дотоодын хөрөнгө оруулалт (k/y; f/y)-ын коэф-фициентээс бус, харин ажиллагсдын тооны өсөлтийн коэффициентээс статистик хамаарал ихтэй байна. Ажиллагсдын тооны өсөлтөөс хамаарах ДНБ-ий өсөлтийн мэдрэмж 0.85 байгаа нь дотоодын хөрөнгө оруулалтаас хамаарах мэдрэмж (0.18), гадаадын хөрөнгө оруулалтаас хамаарах мэдрэмж (0.08)-ийн аль алианаас өндөр, өөрөөр хэлбэл ДНБ-ий өсөлт ажиллагсдын тооны өсөлтөөс илүү өндөр хамааралтай гэсэн сонирхолтой үр дүн гарлаа. Тооцооллоос үзэхэд ДНБ-ий өсөлт нь гадаадын бус харин дотоодын хөрөнгө оруулалтаас илүү их хамааралтай байна. Үл хамаарах хувьсагч болгон авсан дээрх 3 хүчин зүйл нь ДНБ-д гарсан өөрчлөлтийн 74.0%-ийг тайлбарлаж байна.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд Монгол улсад хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалт хэмжээний хувьд үлэмжхэн өсч, ДНБ-ий 15%-тай тэнцэх болсон хэдий ч ДНБ-ий 1989-2003 оны хоорондох өсөлтөд нөлөөлөл багатай байжээ. Онолын хувьд хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг өргөтгөж, бүтээмжийг дээшлүүлдэг боловч бодит амьдрал дээр тийм байдал ажиглагдсангүй.

Монгол улс 1989-2003 онуудад нээлттэй эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилт хийж, худалдаа хөрөнгө оруулалтын илүү

тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн боловч гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ба үр ашгийн аль аль нь хөрөнгө оруулалтыг хүлээн авагч орны худалдааны дэглэмээс хамаардаг тухай Bhagwati (1978)-ийн судалгааны таамаглал Монголын хөрөнгө оруулалтын практикт биелэгдсэнгүй. Үүнийг тайлбарлах хэд хэдэн үндэслэл байж болох юм.

- ▲ Хөрөнгө оруулалт хийж буй олон улсын болон үндэстэн дамнасан корпорациуд хөрөнгө оруулалтынхаа үр ашгийг “шилжих үнэ”-ээр дамжуулан толгой компанидаа төвлөрүүлдэг байж болох юм.
- ▲ Хийгдэж буй хөрөнгө оруулалт нь гол төлөв уул уурхай, нэхмэл сүлжмэлийн салбар гэх мэт техник технологийн багтаамж муутай салбаруудад хийгдсэн тул бүтээмжийг төдийлөн ихээр нэмэгдүүлж чадаагүй байж болох юм. Техник технологийн өндөр хөгжил бүхий улс орнуудаас хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ харьцангуй бага байгаагаас хийгдэж буй хөрөнгө оруулалт хөдөлмөрийн бүтээмжийг төдийлөн нэмэгдүүлсэнгүй.
- ▲ Судалгаанд хамрагдсан хугацааны ДНБ-ий өсөлт нь ХАА, үйлчилгээний салбар гэх мэт хөрөнгө оруулалт бага шаарддаг ажлын байрны тоог ихээр нэмэгдүүлдэг салбаруудын өсөлтөөс хамаарал ихтэй байна. Сүүлийн жилүүдэд ДНБ-д үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин тасралтгүй өсч, 2003 онд ДНБ-ий 51.5%-тай тэнцэх болжээ.³
- ▲ Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн уналт ГШХО-д дийлэнхи хувийг эзэлж буй уул уурхай, МАА-н түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл, ашигт ажиллагаанд муугаар нөлөөлсөн.
- ▲ Хийгдэж буй хөрөнгө оруулалтын багагүй хэсэг нь ашигт малтмалын геологи, хайгуулын чиглэлд хийгдсэн бөгөөд энэ чиглэлийн хөрөнгө оруулалтын үр өгөөж нь ашигт малтмалыг олборлож эхэлсэн үеэс эхлэн гардаг.
- ▲ Монгол улсын газарзүйн байршил, дэд бүтцийн хөгжилт зэргээс шалтгаалан бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох, дотоодод тээвэрлэх зардал өндөр түвшинд байдаг бөгөөд энэ нь хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны үр ашигт тодорхой хэмжээгээр нөлөөлдөг байна. Түүнчлэн татварын өндөр зардлаас зайлсхийн хөрөнгө оруулалттай аж ахуйн газрууд орлогоо их хэмжээгээр нуудаг байж болох талтай юм.

Эрдэмтэн Hanson (2001)-ны нотолж байгаагаар орлогын татвар бага байх нь ГШХО-ыг татахад төдийлөн нөлөөлдөггүй байна. Тиймээс гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд хөрөнгө

³ “Монгол улсын статистикийн эмхтгэл” 2003

оруулалтын илүү тааламжтай орчинг бүрдүүлэх, тухайлбал эдийн засгийн өндөр өсөлт, өндөр боловсролтой ажиллах хүчин, сайтар хөгжсөн дэд бүтцийг бий болгох зэрэг асуудалд илүүтэй анхаарах нь зүйтэй болов уу.

Энэхүү шинжилгээнээс “Гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах талаар анхаарах нь зүйтэй боловч оруулсан хөрөнгө оруулалтыг тогтоон барих, түүнээс үр шимийг нь хүртэх тал дээр бодлогын хувьд илүү анхаарах шаардлагатай” гэсэн гол дүгнэлтийг хийж болохоор байна.

Ашигласан материал:

1. “International financial statistics” 2002, 2003
2. “Монгол улсын статистикийн эмхтгэл 2003” УБ 2004
3. “Монгол улс зах зээлд” статистикийн эмхтгэл” УБ 2004
4. “World Investment Report 2004”
5. “World Trade Report 2004”
6. Banerjee, A., Galbraith, J.W. and Dolado, J. (1990). Dynamic specification and linear transformations of the autoregressive-distributed lag model. *Oxford Bulletin of Economics and Statistics*, 52, 95-104.
7. Clements, M.P. and Hendry, D.F. (1995). Forecasting in cointegrated systems. *Journal of Applied Econometrics*, 10, 127-146.
8. Engle, R.F. and Yoo B.S. (1987). Forecasting and testing in co-integrated systems. *Journal of Econometrics*, 35, 143-159.
9. Harvey, A. (1997). Trends, cycles and autoregressions. *Economic Journal*, 107, 192-201.
10. Hendry, D.F. (1995), *Dynamic Econometrics*, Oxford University Press, Oxford.

Интернет хаягууд:

1. World Bank Group; IBRD, IDA, IFC, MIGA, ICSID - <http://www.worldbank.org>
2. International Monetary Fund (IMF) - <http://www.imf.org>
3. World World Trade Organization (WTO) - <http://www.wto.org>
4. UN Databases - <http://www.unctad.org>